

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

L371

Ринчэнгийн Равжаа

Он сар өдөр, төрсөн газар	1925, Дундговь аймгийн Говь-Угтаал сум
Үндсэн сүм хийд	Баруун ганжуурын хийд
Б.Ринченгийн сүм, хийдийн нэр	Баруун ганжуурын хийд
Ярилцлаганд дурдагдсан бусад сүм хийдүүд	Зүүн Ганжуурын хийд, Бороолон жас, Гучин жас



- Хэдэн онд анх лам болсон бэ, багадаа?

5 настай анх лам болсон.

- Хэдэн онд гэсэн бэ?

Одоо мэдэхгүй. Би одоо наян гуравтай.

- Ямар жилтэй вэ, та?

Үхэр жилтэй.. 1924, 1925 онд төрсөн гэж байдаг юм.

Баруун ганжуурын хийд хэдэн дугантай байсан бэ?

Гурав ч байсан юм биш ээ, 5 ч байсан, 6 ч байсан юм, 7 ч байсан юм.

- Ямар дуганууд байсан вэ?

За, би хэлээд өгье. Ламримын дуган гэж байсан, би цухас хэлэх гэж байгаа юм шүү. Тэр бол Гомбо сахиустай, тэр сахиусыг голлон шүтдэг. Ганжуурын дуган гэж байсан. Тэр нь Балдан Лхамо сахиустай. Дүйхорын дуган гэж байсан. Тэр нь бол Жамсран сахиустай. Дүйнхорынх нь гэдэг нь тусдаа 3 дуган байсан юм. Урагшаа эгнэсэн үргэлж 3 дуган байсан. Хийд туурин дээр очиход байгаа. Хамгийн хойдоход нь би бага байсан болохоор биднийг ойртуулдаггүй шилэн юу гэмээр юм нэг тийм сав байсан юм. Тэр дотор лайлүн гэдэг нэртэй зүйл байсан тэр дотор нь юу байсан бэ гэхээр Ринчендагва хаан гэдэг хүрэн халзан морьтой хаан байсан юм. Чавхадсан ч юм шиг морьтой хаан байсан. Түүний урд талд нь Жамсран сахиустай хурал хурж байсан юм. Хамгийн адгийнхад нь голлон зүүн гэрийг цутгах гэж гал түлж байгаа юм. Тэрэн гал түлэхэд янз бүрийн өвс тэгээд шанага шанагаар л шар тос дүүргээд байдаг. Их олон зүйл хийж л түлж байсан. Түүний шатсан үлдэгдэл нь бол тухайн үедээ малын өвчинд их сайн хэмээн үздэг байсан. Ганжуурынх гэж хэлсэн шүү дээ, нэг ёсондоо Балдан лхамо сахиустай хурал хурж байдаг. Тэр чуулганых гээд нөгөө тэнд бол лам нар суудаггүй, бүүр дан бурхан. Цаана нь Ганжуурынх гэж байгаа, тэр нь бас дүүрэн ном бурхан байдаг, зул хүж өргөдөг нэг тийм газар байсан юм. Та нар олон газар үзэх юм байгаа юм биз дээ.

- Тийм.

Тэнд Зүүн, Баруун ганжуур гээд олон байгаа шүү дээ. Ламримынх, Дүйнхорынх, Ганжуурынх гэдэг чинь тус тусдаа хөрөнгөтэй, тус тусдаа хурлаа хурдаг байсан.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

- Баруун ганжуур нийт хэд орчим ламтай байсан бэ?

Намайг байхад 130 лам байсан, баруун ганжуур. 4, 5 жас байгаа биз дэ? Ламримын жас, Ганжуурын жас, Дүйнхорын жас, Хайлан гээд чуулганых гээд 6 ч жас байсан юм болов уу даа.

- Хамба лам нь хэн гэж хүн байсан бэ?

Хамба лам их солигдсон. Хамгийн сүүлийн хаагдаж үгүй болох үед нь Жамбариндэл гээд лам байсан. Цам харайдаг хүн байсан юм.

- Цам харайдаг байсан уу?

Тийм, манай Ганжуур дуганд хоёр янз байсан юм. Тэрний нэг бол нөгөө өмнө нь ярьсан угсраа 3 дуган гээд тэрний урд дотор нь харайдаг. Нэг нь бол дуганаасаа урагшаа гараад хийдэг байгаа юм. Дугуй хаяатай газар гэх үү тийм маягтай, одоо нэг гараад бүжиглээд гараад байна шүү дээ, тийм газар хийдэг юм байгаа юм. Азар 2 мод барьсан гэж маягтай юм байдаг байсан, одоогоор бол цагдаа л юм даа. Модоо бариад явахаар нь хүмүүс цаашаагаа гэдийгээд явдаг байсан.

- Хэдэн баг гарч байсан бэ?

Мэдэхгүй байна. Бага байсан болохоор нарийн зүйл мэдэхгүй.

- Цамаа харайгаад жинсрэг цутгадаг байсан уу?

Тийм, цамаа харайчаад дугандаа орж хувцсаа хүлээлгэж өгөөд, өөрсдийн хувцасыг өмсөөд гэртээ харьдаг байсан.

- Цамаа дуусаад сор залдаг байсан уу?

Үгүй, сор гэдэг бол 29 гэж байдаг шүү дээ. Тэр үед болдог тэгэхдээ нутгийнхаа бүхий муу муухай бүхнийг арилгахын тулд үйлддэг байсан.

- Цам хэзээ харайдаг байсан бэ?

Хавар болдог байсан санагдаж байна. Нэг 15-нд харайдаг. За мэдэхгүй юм

- Майдар эргэдэг байсан уу?

Тиймээ, бас л нээх удахгүй л эргэдэг байсан. За Майдар гэдэг дөрвөн дугуйтай тэргэндээ хоёр ямтай, Майдар бурхан дотор нь, одоо тэр хоёр хүний хооронд, тэгээд одоо түүнийг чирээд явна. Урт оосроор тэр хашаа хүртэлх оосроор оосорлочихоод тэгээд чирээд л явна. Ийшээ явах гэж байгаа бол энэ талынхаа оосрыг татаад, тийшээ явах гэж байгаа бол тэр талынхаа оосрыг татна, дунд талых нь чигээрээ явуулдаг байсан. Хүн бол ерөөсөө шаваатай яг ингээд нам дагаад явна.

- Дуганд харайдаг байсан цамыг мэдэх үү?

Аа тэрнийг Дотуур цам гэдэг байсан. Зай багатай л гарна шүү дээ, бас л адилхан.

- Дуганд олон хүн байсан уу?

Тэр гадаа байгаа чинь дотор байгаа шүү дээ. Тэр бол ялгаагүй нэг үеийнхэн нь дотроо, нэг үеийнхэн нь гаднаа л болохоос биш адилхан.

Улс даяар шүтэгдээд байдаг, би бол мэдэхгүй. Манай хийдэд надаас өмнө нас барсан хүн байгаа юм даа, одоо энэ улс даяар л шүтэгдэж байгаа байх даа, Жалсрай хувилгаан гэж тийм л хүн байгаа юм. Манай Ганжуур хийд хоёр янзын байгаа юм, тэр он, байгуулагдсан он нь. Хоорондоо нэг бага зэрэг ондоо. Хоёр зуугаас нэг хагас жилийн өмнө байгаа юм шүү дээ. Байгуулсан оныг тэмдэглэсэн. Энэ дээр байгаа хийд хоёр янз байгаа. Шарагчин үхэр жилээр хоёр зуун жаран долоо, шарагчин хонин жилээр хоёр зуун гучин долоо. Ийм жил болоод хаагдсан даа. Би эртээд нэг хүний нэр хэлээ биз дээ? Лувсанжалсрайданзанбалсанбуу гээд. Тид ринбүүчи хамба Чойжамц, Лувсанжалсрайбалсанбуу. Энэ хүн Баруун ганжуур хийдийг байгуулсан хүн шүү дээ. Энэ хүн бол, за яахав, зарим хүмүүс бол худлаа хэлж байгаа байх ч гэж бодох байх, ухаандаа голцуухан буугаар буудаж юмыг дардаг, одоо энэ номон дээр гарч байгаа. Наймдугаар богд гэж ярьдаг шүү дээ, тэр наймдугаар Богдыг Төвдөөс авч ирсэн хүн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лувсанданзанжамц – энэ ламыг (Лувсанжалсрай балсанбуу) нас барсны дараагаар энэ лам тодорч гарч ирсэн хойд дүр нь гэж үздэг. Лувсансодном манайхны лам нар бүгдээрээ нэрийг нь хэлдэггүй, бүгдээрээ Ганжуурва багш гэдэг том лам байсан юм. За ийм учиртай лам байгаа юм аа. Ганц нэг түүхээс нь ярихад Богдыг залж ирсэн, өвчин зовлон хижиг болоход гэртээ аргалдаг гэж настангууд ярьдаг байсан юм. Баруун ганжуураас холгүй Зүүн Чойр гээд байгаа, тэнд их өвчин гараад байхад дуган дацангаар нь үймэлдээд хоёр гурав хоноод гайгүй болгож байсан.

Тэгээд Лувсанжалсрай хувилгааны тухай ярьвал их юм бий... Архи ч уудаг хүн байсан юм байна. Одоо тэр чулуугаар чинь гал түлээд, тэр Богдыг дулаацуулж байсан гэж байгаа юм. Дөрвөлжин шугам шиг юм хийгээд, ингээд хоёр морины дунд модоор дамжуулаад явдаг байсан юм гэнэ лээ.

- Одоо нэг хуучин Баруун ганжуур хийдийн бүдүүвч зураг зурах гэсэн юм. Цогчин дуган энд байсан бол гээд тэмдэглээд үзэх үү, хэдүүлээ?

Яг очихоор тэр олон гэрүүдийн буурь бол яг байгаа. Та нар ч өнөөдөр иргэж ирэхгүй байх аа.

- Бид хэд маргааш яваад өдөртөө иргэж ирнэ. Та явж чадах уу? Та цуг яваад заагаад өгвөл их сайхан байна.

Би чинь Баруун ганжуур хийдийн хаана байсаныг заана шүү дээ. За, тэгвэл тэгье.

Маргааш өглөөгүүр явья. Зүүн ганжуур луу бас явсан ч яахав, ерөнхий нэг заагаад өгч болно.

- Хайлан хурдаг байсан биз дэ?

Тийм ээ, долоон хүн хурдаг байсан юм, намар.

- Аль дугандаа хурдаг байсан бэ?

Тэр дугантай, Хайлангийн дугантай. Тэр долоон гэлэн бол үдээс өмнө юм иднэ, үдээс хойш юм идэхгүй. Цай бол уудаг л юм.

- Хийдийн орчимд зөндөө олон лам байсан уу?

Байхгүй, их хол байна. Тэр зураг бол тодорхой бий бий, очоод заагаад өгнө.

- Хятадууд байсан уу?

Байхгүй, тэр бол байхгүй.

- Энэ дуганууд чинь модон дуганууд байсан уу? Эсвэл...

Дандаа мод.

- Аль овоогоо тахидаг байсан бэ?

Одоо энэ харалдаа Баян-Улаан гэдгийг тахина. Зулзаган ганжуур, Угтаал уулзвар гэдгийг тахина.

- Худаг ус нь хаана байсан бэ?

Худаг гэж бараг байхгүй, Баруун ганжуурт.

- Амны рашаан гэж байсан уу?

Том булаг гэдэг байсан юм .

- Баруун ганжуурт нь уу?

Тийм . Тийм булаг одоо ч бий. Их булаг бий. Тэнд одоо цувсан гурван булаг байдаг юм.

- Зоч байсан уу? лүйжин тавьдаг...

Тэр байсан, арван нэг хоёр, дандаа залуучуул байсан.

- Тэгээд тусдаа дугантай байсан уу?

Дугантай, Жодын дугантай.

- Цугтаа эсвэл зайтай юу?

Хол холхон. Ухаандаа тэр хийдийг тойрсон эргэн тойрон замтай. Түүнийхээ дээд өнцөгт нь тусгайдаа тийм дугантай.

- Лүйжин тавьдаг ламуудыгаа санаж байгаа юу? Хэн гэж хүмүүс байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хэлээд өгч болно. Одоо тэр лам нар бол байхгүй шүү дээ. Тангуу гэж хүн байсан юм. Манай энэ хөгшний эцэг нь тийм лам хүн байсан юм. Содголин, Чойжамц, Дамчой, Шарав зурхайч Шарав, гэлэн Лувсандорж, Минжуур гуай лам, Балдан гуай, Санжайцамц лам байсан юм.

Зоч болно гэдэг чинь нэг цөөн хоног, 108 хоног хөдөө ганцаараа байна. Ямар ч хүнтэй уулзахгүй, яг л ганцаараа. Жоохон жодгор гээд савтай, тэрэнд нь нэг ширдэгтэй, том тэрлэгтэй, нэг хөвөнтэй дээлтэй, зоч хүний хонх дамартайгаа, өөр ч юм байхгүй дээ. За тэгээд хийдэд ойрхон, за ядаж нэг хүн одоо идэж уух юм ойртуулдаг, за тэгээд хөдөө гадаа “За чи хоолоо ид” гэхгүй, тэгээд л хаячихна. Яг л 108 хоног л хүнтэй уулзахгүй, хүнтэй ярихгүй, өөрөө яваад цайгаа чанаж, хоолоо хийж идчихээд, өдөр бүр бууна. Нэг жоохон чулуугаа өнхрүүлээд, тэр чулуу нь хаана бууна, тэнд бууж номоо уншина. Тэгээд 108 хоног тэгж явна. Тэгээд ухаандаа чөтгөрийг дардаг.

- Жодын жүд нь юу байсан юм бол?

Тэрнийг сайн мэдэхгүй.

- Хандмаа байсан уу?

Тэр байхгүй ээ.

- Чойрын дуган байсан уу?

Чойр байхгүй. Чойр гэж тус тусдаа шүү дээ.

- Баруун ганжуурт байгаагүй юу?

Байхгүй. Баруун ганжуурт ч байхгүй, Зүүн ганжуурт ч байхгүй.

- Суваргууд олон байсан уу?

Олон байгаагүй, дундуураа нэг, нэг л суваргатай.

- Гавж лам олон байсан уу?

Гавж лам манайд цөөхөн байсан, Чойрт их хүн байсан. Гэлэнгүүд л олон байсан.

- Дуган болгондоо цорж, ловон, гэсгүй, хамба гээд байсан уу?

Хурал хуралд байна. Харин хурал эхэлдэг унзад гэдэг хурал болгонд байна. Хамба гэдэг хүн ганц байна. Бүх хийдийг л толгойлж байгаа хүн шүү дээ, энэ хүн. Нярав бол тус тусдаа, мал хөрөнгө нь тусдаа, унзад бол тус тусдаа, гэсгүй ердөө хоёр л байгаа. Тэр Ламрим, Дүйнхор хоёр нэг нэг л гэсгүйтэй, тэр хоёр бүгдийг л захирч тэнд сууж байгаа.

Дүйнхорын бэрээ гээд тэр гэсгүйгийн барьж суудаг зүйл байдаг шүү дээ, тэр нь ташуур нь юм гэнэ лээв Тэр хүн бол хүнд арга хэмжээ авахаар болбол түүгээрээ хүнийг цохиж байдаг юм гэнэ лээ.

- Ганжуур хийд байгаа хийдэд байсан ганжуур нь Алтан ганжуур байсан уу эсвэл Бэхэн ганжуур байсан уу?

Хоёр янз байгаа. Одоо Бэхэн ганжуур гэж байна, нөгөөх нь Шунхан ганжуур байсан юм.

- Төвдөөр бичсэн үү?

Тэгэлгүй яахав, дандаа төвдөөр бичсэн.

- Монголоор бичсэн байсан уу?

Байсан байх аа. Тийм нарийн юманд чинь хүүхэд оруулахгүй шүү дээ. Шунхан ганжуур 108 ботьтой, нөгөө Бэхэн ганжуур нь 124 ботьтой гэж байсан. Шунхан ганжуур нь бол модон хавтастай. Тэгээд хавтаслаад тэрнийгээ боодог.

- Цогчин дуганы гол сахиус нь юу байсан бэ?

Юу байхав дээ, Жамсран бурхан. Тэр л их догшин бурхан гэж байсан юм даа. Бага байсан болохоор адис аваад гардаг байсан болохоос биш.

- Том том дуганууд байсан уу, давхар дуганууд байсан уу?

Жирийн л дуганууд байсан. Том дуган гэдэг нь найман морьтой. Тэр найман морь гэдэг нь хойшоо урагшаа хүн сууж байгаа шүү дээ.

- Ганжуураа хэзээ хурдаг байсан юм?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Зун.

- Зүүн ганжуурын тухай мэдэх үү?

- Зүүн ганжуурын тухай би мэдэхгүй. Хоёр гурван том дугантай байсан.

- Эмгэн түлэгтийн нид хаана байгаа вэ?

Баруунтаа байгаа гэсэн. Би тэгэхдээ сайн мэдэхгүй ээ. Дөрвөн жас байсан юм гэнэ лээ. Жоохон газар. Харнууд, Хамар, Ламд, Равжай хийд байсан юм гэнэ лээ. Лам нар тэнд суухгүй. Нэг хоёр дуган байсан байх. Зүүн, Баруун ганжуурын лам нар намар хурал хурдаг, цагийн хурал хурдаг. Энүүхэнд манай гэрийн энд нэг хийд байсан юм, манай хийдээс өмнө, Бороолон жас гээд.

- Сумийн зүүн талд нэг суварга босгосон байна. Тэнд хуучин жас байсан уу?

Байхгүй. Энэ чинь тэндээ анхлан байгуулагдаад энд ирээд, тэнд буусан байгаад байгаа юм. Богдын гал тогооны газар гээд тэрнийг харин шавраар хийсэн байдаг юм. Манзын тогоо гэж том тогоо байгаа. Лам нарын манзыг хийхэд цайг голоор нэг хуваагаад л хийдэг байсан гэдэг. Тахилын усыг аваачаад хаячихгүй бүгдийг л авдаг байсан.

- Хагат уулын өвөрт нэг жас байна. Дуутын суурийн гэж байсан юм гэнэ лээ.

- Баруун, зүүн цоор гээд тэр нь?

Би бол сайн мэдэхгүй юм байна, Дуутын жасаас ондоо. Хонгор бригад зүүхэн хойно, бас хөөрхөн мод, жоохон юмтай жас байсан юм билээ. Би бас тэрнийг үзээгүй ээ.

- Хонгор Бригад эндээс хэдэн км вэ?

23

- Бригадаасаа цаашаа ойрхон уу?

2-3 км орчим байна уу..

- Цагаан уулын хажууд байгаа юу?

Үгүй ээ, бас нэг энүүхэнд байгаа хойно нь нэг өндөр уул бий дээ тахидаг.

- Аан, тэгвэл тэр нь зүүн баруун цээжинд байгаа тэр үү? Тэнд байхгүй биз? Энэ талдаа нэг худагтай? Биш үү?

Биш ээ..

- Бид хэд сая нэг 2 жасаар очлоо. Нэг нь нэг Цагаан уулын цагаан эрэг гэдэг жас байна.

Цагаан уул гэдэг газар. Нөгөөх нь нэг зүүн баруун цээжинд нь .

Цагаан дэлгэрийн нутаг гэж байна уу?

- Тийм, тэгээд наад талдаа Залаа уулын Их залаа уул хажууд. Тэрний энгэрт байсан.

Тийм, баруун сугаар нь тэр сая цоор гэж яриагүй юу. Тэрнийг мэднэ шүү.

- Тийм Цагаан уулын баруун сугаар нь байсан юм, тэр нөгөө баруун зүүн цоор мөн үү?

Мөн болов уу? Цоор л гэдэг юм гэнэ лээ. Тэгж дуулсан. Тэр цоор биш үү, тэр наана байгаа нь Буурцагтын жас юм байна. Гучин жас.

- Хонгор бригадын зүүхэн хойшоо ямар нэртэй газар байдаг юм бол?

Гучдын ус гээд бий, тэнд байсан юм шиг билээ. Хүнээс асуугаарай тэр хавиас, сайн хэлээд өгөх байх.

- Сумын төвийн хийд хэдэн онд яаж нээгдсэн бэ?

1990 онд байгуулсан байх.

- Дуганыг анх хэн гэдэг хүн босгосон юм?

Энэ одооны дуганыг Найдан гэдэг хүн. Арай түрүүний нэг дуган байгаа. Бага дуган гээд. Тэр бол тэр Баруун ганжуур дээр би түрүүн зоч Чойжамц гэж хэлээ биз дээ. Тэр хүний сууцны байшин эхлээд. Тэр лам бол баригдаад явцан. Хураагдаад ирсэн. Хураагдаж ирээд сумын захиргааны контор байж байгаад сүүлдээ тэр дуганаар их дуган болгосон. Тэр хуучин Ганжуурын дуганд ганжуур л байгаа л даа. Тэр байшин бол 3 тасалгаатай. Тэр Чойжамц гуай тэр байшингийн жоохон

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хэсэгт байдаг, араар нь гэрээ хураадаг тийм байсан гэдэг. Тэгээд сумын захиргаанд олон жил болсон юм даа.

- Урд хийдийг 1990 онд байгуулахад хэдэн настай лам нар байсан бэ?

Дээд тал нь 98 хүрээд нас барсан. Эхлээд 3 ламтай байж байгаад, тэгээд 20-иод лам болсон. Тэгээд өвгөчүүл чинь дандаа байхгүй болсоор байгаад, 2 бага лам байсан. Тэгээд сургууль гээд тэгээд одоо лам байхгүй.

- Анхны гурван лам нь хэн хэн гэж байсан бэ?

Хайдав, Лувсаншарав, Чойнпэл. Би бол 3-4 жилийн дараа очсон.

- Хамба лам нь?

Гончигчүлтэм гэж байгаад таалал төгссөн. 85тай байж байгаад. Манай энэ хийдэд нэг английн хүн их тус болсон гэж байгаа юм. Би нэрийг нь тогтоогоогүй. Эмэгтэй. Манайд хэд хэд ирсэн. Ганжуурт тусалсан. Дуганд хандив өгсөн,. Английн л нэг хүн дээ. Одоо ч ирэхгүй л байна.

- Английн эмэгтэй хүн байсан уу?

Тийм .Английн нэг хэсэгт буддын шашинтай юм байлгүй . Түүний нэг сангийн юм уу даа, нярав хүн юм шиг байна лээ. Хэд хэд ирсэн. Нэр нь одоо Жий билүү Жоо гэл үү, тийм л нэртэй.

- Төвдийн сангаас ирсэн эмэгтэй хүн үү?

Тэр нь хариуцсан хүн гэсэн. Англи дотор нэг багахан газар байдаг юм байгаа юм биз дээ. Тэр Англи ч ямар бурхан шашинтай хүн байгааг хаа газар яаж мэдэхэв. Тэрэн дотор байгаа хэсэгхэн хариуцдаг хүн.

Манайхаар бурхан шашинтны сургуулийн захирал Сонинбаяртай их холбоотой хүн юм шиг байгаа юм. Тэгээд тэр хүнтэй холбогдож өргөл хандив өргөж байсан юм билээ.

- Баруун ганжуур хийдийн газрын зургийн тухай...

За, энэ бол одоо Дүйнхорынх гэдэг айл. Тусдаа хуралтай, тусдаа номтой. За, Ганжуур жас гэж би хэлж өгсөн. Энэ Шуурганых гэдэг дуган.

Энэ нэг тэрэг байгаа. Энэ тэргийг энэ үхэрт хөллөнө. Энэ гурван улаан үхэр байгаа.

Энэ бух. Би ярьсан болов уу даа..Бага хувилгаан гэж ярьж байсан, тэр айлын бухыг зурсан юм билээ.Дандаа тэрэг байгаа биз дээ, ногоон тэрэг байгаа. Тэрүүгээр байнга ус зөөдөг юм.

Нохой байна уу? Шинийн 15, 29, битүүнд энэ жасын шар будааг учиргүй чанаад, энэ гурван жас түгээдэг юм.

- Энэ хойд талд түлээ байх шиг байна. Тиймээ?

Тийм ээ, аргал байгаа юм.

Энэ нөгөө Зүүн хүрээ гэж, энэ нөгөө Баруун хүрээ гэж байна. Энэ миний сууж байсан гэр.

Энэ цоохор юм байгаа биз дээ . Энэ бол одоо урагдсан ном, хэмхэрхий бурхан, энэ дотор хийдэг, хамаагүй хаяагүй юм.

Энэ дөрвөн шовгор юм байгаа биз дээ. Нэг нь суваргатай байсан юм. Суварга нь энэ байна. Энэ бол Ганжуур хийдийг модоор хийсэн байсан. Энэ бол одоо будгаар л буулгасан байгаа болохоос биш, яг л одоо алдаа нээг их гараагүй.

Энэнд хурал хурахад ямар болохыг, энэ дотор хоёр хүүхэд сууж байдаг юм. Тэгээд энэ хавьд нэг дугуй юм байна уу, үгүй юу?

- Усны сав байх шиг байна. Усны сав мөн үү?

Шаарны сав. Шаар хийдэг. Усыг үхэр хөллөөд л авна.

Энэ бол Ганжуур жас гэнэ. Энд хүрд байгаа. Ногоон өнгөтэй.

Энд нэг ганц гэр байна уу? Тусгай. За, энэ гэр бол өмнө нэг Лувсансодов гээд хүний нэр бичүүлсэн дээ. Тэр хүн хойшоо татагдаад явсан, тэр хүний гэр.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Энэ хоёр байшин гадагш нь гаргасан юм бэ? гэхээр бас нэг Жалсрай хувилгаан, тэр ламыг жанч халахаар нь энд жил гаран хадгалсан юм. Энэ дандаа айлууд, байшинтай үүдэндээ амбаартай.

- Энэ цамын талбайд байгаа өнгөтэй юмнууд юу вэ?

Энийг ч одоо сайн мэдэхгүй байна даа. Энд тэгээд одоо цам харайж байгаа улсууд энд байдаг байсан болов уу гэж санаж байна. Би бас сайн санахгүй байна. Нас өндөр болохоор худлаа хэлэх гээд байна. Баруун ганжуур гэж нэг ийм л юм байгаа юм даа.

Энд 130-аад лам байсан одоо надтай 4 хүн бий. 85-тай нэг хүн бий, 82-той нэг хүн бий, 83-тай нэг хүн бий. Нэг нь хотод, хоёр нь хөдөө байгаа.

Харж байгаад асуухаар зүйл байвал би хэлж өгнө шүү. Нэг булаг байсан, тэр нь багтаагүй юм билээ. Одоо тэр булаг нь бол урсаж байгаа. Айлууд бол дан байшинтай байсан. Амбаартай байсан. (Сахиусны өрөө лүү явав.)

За энэ Гомбо сахиус гэдэг юм. Махгал ч гэж нэрлэдэг. Тэгэхдээ энэ баруун талынх нь Ламримынх гэж зааж өгсөн шүү. За, тэр бол гол шүтээн нь, ийм шүтээнтэй юм.

За, энэ байна, Ганжуур хийдийн шүтээн. За, энэ бол яг хуучнаараа тухайн үед хэрэглэгдэж байсан. Хамба Цамбамөрөн гэж тэр хүн хадгалж байсан юм билээ.

За, энэ Дүйнхорынх. Нөгөө гурван залгаа дугантай Жамсран сахиус голлон шүтдэг. Бусад сахиус бол байгаа л даа. Тэр Зүүн ганжуурын гол сахиус бол тэр цагаан Гонгор гэдэг сахиус. Тэр Махгал энэ хоёртой байсан газар, хамгийн том сахиустай байсан.

За, энэ Зүүн ганжуур гэдэг нь энэ. Би одоо бас сайн тайлбарлаж бол чадахгүй. Энэ гол дуган нь Цогчин дуган. Манайхыг бодвол энэ худгаас ус аваад явдаг. Энэ лам нар дугандаа орж байна. Нэг ийм хэдэн дугантай байсан юм гэнэ лээ. Би бол одоо бага байсан болохоор сайн мэдэхгүй.

- Том тогоо нь гадаанаа байдаг байсан уу?

Энэ шавар байшин байгаа, тэрэн дотор том зуухтай. Хоёр зуухыг зэрэгцүүлээд тавьсан. Нэгэнд манз, нөгөөд цав чанана. Гадаа байна гэж байхгүй, дотор байна. Ухаандаа гэрт ч юм уу, эсвэл байшинд юм уу, байна. Энэ бол дан дуган. За энэ дуганд бол ном хурахгүй. Дүүрэн номтой.

- Энд хэд орчим лам байсан бол?

Энд бас нэг 130-аад орчим лам байсан гэж ярьдаг юм билээ.

- Лүйжин тавьдаг зоч лам нар байсан болов уу?

Лүйжин тавьдаг Зоч лам байсан гэдэг юм билээ. Би сайн танихгүй. Нэг хамба хүн байсан юм гэнэ лээ. Шавраар бүрчихсэн. Надаас өмнө л болсон юм гэнэ лээ. Тийм нэг хувилгаантай байсан юм гэнэ лээ. Ус наянтарвагай гэдэг ус энэ хийд уудаг байсан гэсэн.

- Хэн гэж хүн энэ зургийг зурсан бэ?

Хайдав гэж нэг хүн хотод байгаа байх. Энгийн хар хүн. Энэний өмнө билэгт мэргэн Баяраа гэдэг хүн зурсан.

- Зүүн ганжуурын туурин дээр суварга босгосон гэсэн тэр хаана байгаа бол?

Энэний туурин дээр Төрөө лам гэдэг хүн босгосон. Хаана босгох вэ гэхэд Цогчин дуганы туурин дээр босгосон.